

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАРУУНБҮРЭН СУМЫН ГЭРЭЛТҮҮЛЭГ ТАВИХ, ЗАСВАРЛАХ
АЖЛЫН ТЕХНИКИЙН ДААЛГАВАР**

1	Хөрөнгө оруулагч захиалагч байгууллага	Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сум, ЗДТГ
2	Барилга угсралтын ажил гүйцэтгэх үндэслэл	Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 сарын 20-ны дугаар 58–р тогтоол
3	Гэрэлтүүлэг тавих газрын байршил, бусад мэдээлэл	Үнээн фермийн зүүн хойд булангаас фермийн хашааны замын дагуу явж
4	Зориулалт, хүчин чадал	<p>Шинээр 21 шон гэрэлтүүлэг тавих Гэрэлтүүлэгийн шон нь үйлдвэрийн гагнаас будагтай, төмөр бетон сууринд суух зориулалтын байна.</p> <p>-Гэрэлтүүлэг нэг тулгуур дээр 150 вт чадалтай гэрлийн өнгийн температур 4000 к -Гэрэлтүүлэгийн ажиллах хүчдэл Ажиллах хүчдэл -380 В Давтамж герц -50 Ашигт үйлийн -98% Гүйдэл А -0.68 Чадлын коэффцент $-\cos\phi \geq 0.98$ Хэрэглэх чадал вт -150 вт Нийт гэрлийн урсгал лм –20000 Өнгөний температур / байгалийн шаргал / К -4000 Ажлын температур $^{\circ}\text{C}$ -40$^{\circ}\text{C}$ +65$^{\circ}\text{C}$ Суурилуулах орчин -УХЛ-1 Гэрэлт деодын хамгаалалтын зэрэг IP 67-68 Ажиллах хугацаа- 50 000 цагаас багагүй байна. Гэрэлтүүлэгийн самбарын газардуулагын эсэргүүцэл нь 4 Ом-оос ихгүй харин гэрэлтүүлэгийн шонгийн газардуулгын эсэргүүцэл 380В-ын тэжээлийн шугамд 30 Ом-оос ихгүй байна.</p>
5	Гэрэлтүүлэгийн угсралтын ажлын цар хүрээ	<ol style="list-style-type: none"> Одоогийн нөхцөл байдлын талаарх танилцуулга, гэрэлтүүлэг тавих, засварлах угсралтын ажлыг гүйцэтгэх аргачлал, төлөвлөгөө гаргах Гадна инженерийн шугам сүлжээний одоогийн нөхцөл байдлын талаарх судалгаа хийх Шинээр 21 шон гэрэлтүүлэг тавих Төлөвлөсөн гэрэлтүүлэгийн тэжээлийг техникийн нөхцлийн дагуу одоо байгаа АТП -187 дэд өртөөний 0.4 кв-ын шитнээс шинээр гаргалгаа гаргаж 0.4 кв-ын ЦДАШ-барьж 1-р тулгуурт тооллуурын хайрцаг, 9-р тулгуурт гэрэлтүүлэгийн удирдлагын самбарыг газрын тэгшлэгдсэн төвшингөөс дээш 1.6 м өндөрт байрлуулна.

		<ol style="list-style-type: none"> 5. Гэрэлтүүлэгийн тэжээл нь 380 втын СИП-2 А маягийн 3x16+1x25 хөндлөн огтлолтой дамжуулагчийг агаараар,гэрэлтүүлэгийн шугам 0.4 кв-ын болон 0.22 кв шугамтай огтлолцож байгаа хэсэгт АВВБ маягийн 3x16+1.10 хөндлөн огтлолттой кабель шугамыг газраар татна. 6. Газардуулагын системп TNC-S системийг ашиглах тул гэрэлтүүлэгийн группуудад дифференциал автомат тоноглосон байна. 7. Газардуулаг нь тооллуурын самбар,гадна гэрэлтүүлэгийн самбар болон гэрэлтүүлэгийн шонгийн хэвтээ хүрээг 10 мм-ийн диаметртэй дугуй огтлолттой төмрөөр босоо электродыг 2 м-ийн урттай 20 мм-ийн диаметртэй цул дугуй огтлолттой төмрөөр хийнэ.Гэрэлтүүлэгийн шон бүрийн эх биеийг газардуулсан байна. 8. Газардуулагын хэвтээ хүрээг газрын тэглэгдсэн төвшингөөс доош 0.8 м-ийн гүн шуудуунд суулгаж босоо электродыг өрөмдөх замаар газарт зоож гагнууран холбоосоор холбож өгнө.Газардуулга нь TNC-S систем ашиглаж дифференциал автоматаар хамгаалсан тул гэрэлтүүлэгийг холбох үедээ нойлтуулга хийж болохгүйг анхаарах хэрэгтэй. 9. Угсралтын ажлыг зураг төслийн дагуу болон цахилгаан техникийн ажил “БНБД -3.05.05.06-90-ийг мөрдөж гүйцэтгэвэл зохино.Бүх газар шорооны ажил,угсралтын ажлын үед цахилгаан шугам сүлжээний байгууллагаас мэргэжлийн хүмүүс байлцуулах шаардлагатай. 10. Гадна цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх 11. Төсөвт өртгийг зураг төсөл, техникийн тодорхойлолтын хүрээнд боловсруулж эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулж ирүүлэх ба төсвийг Монгол улсад хүчин төгөлдөр хэрэглэгдэж буй хууль, тогтоомж, журам зааврын дагуу төсөв зохиох Estimator pro программаар гүйцэтгэж эрх бүхий төсөвчнөөр баталгаажуулах
6	<p>Шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр</p>	<p>Нийт төсөвт өртөг: 60 000 000 /Жаран сая төгрөг/</p> <p>Эх үүсвэр: Аймгийн Замын сангийн хөрөнгө оруулалтаар</p>
7	<p>Галын аюулгүй байдлын нөхцөл</p>	<p>Гэрэлтүүлэгийг стандартын дагуу тавих</p>